

Н.БАЯРТСАЙХАН: БИ ТӨВ БАНКНЫ БИЕ ДААСАН БАЙДЛАА ХАМГААЛНА

МН25 дугаар суваг телевизийн “Ам нээвэл” зочны ярилцлагын цагт Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан оролцож, Төв банкны бодлого, үйл ажиллагаа, өөрийн амьдрал, үзэл баримтлалын талаар дэлгэрэнгүй ярилцсаныг бүрэн эхээр нь хүргэж байна.

-2018 ГЭХЭД ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, ХӨГЖЛИЙНХӨӨ ЗАМД ОРНО-

-Шинэ ажлын эхний өдөр Төв банкны Ерөнхийлөгчтэй уулзаж байгаадаа билэгшээж байна. Энэ онд эдийн засаг ямар байхаар байна вэ, төлөв байдал ямархуу байна вэ?

-Юуны өмнө шинэ оны эхэнд уулзаж байгаадаа баяртай байна. Та бүхэндээ шинэ оны мэнд хүргэж, ажил үйлс өөдрөг, сайн сайхан байхыг хүсэн ерөөе. 2017 оны хувьд нуугаад яах вэ, амаргүй жил эхэлж байна. Энэ онд бид Хөгжлийн банк, Чингис бондын өрийг төлнө. Мөн Хятадын ардын банктай байгуулсан свопын гэрээний хугацаа дуусч байна. Амаргүй жилийг даван туулна гэдэгтэй итгэлтэй байна. Дангаараа даван туулахад амаргүй учраас олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын дэмжлэгийг авна гэж тооцоолж байна. Ингээд 2018 оноос Монголын эдийн засаг өсөлт, хөгжлийнхөө замд орно гэж харж ажиллаж байна.

-Хятадтай хийсэн своп хэлцлийн хугацаа энэ онд дуусч байна. Одоо ОХУ-тай своп хэлцэл хийх талаар ярилцаж байгаа гэсэн. Энэ үйл явц ямар шатандаа явж байна вэ?

-ОХУ руу манай Тэргүн дэд Ерөнхийлөгч айлчилсан. Айлчлалынхаа үеэр Монголбанкны Ерөнхийлөгчийг ОХУ-д айлчлуулах чиглэлээр бид ажиллаж байна гэдгийг онцолсон. Бид ОХУ-тай своп хэлцэл хийе гэж бодож байгаа. Яагаад гэвэл ОХУ-д манай улсын иргэд визгүй зорчдог болсон. Надад байгаа мэдээллээр өдөр бүр 500 гаруй машин ОХУ руу гарч байна. Нэг иргэн дунджаар худалдаа наймаа хийхийн тулд 1000 ам.доллар аваад гарч байна гэж тооцвол өдөр бүр 2 сая ам.доллар ОХУ руу гарч байна. Тэгэхээр бид ОХУ-ын Төв банкинд асуудал тавьж байгаа. Танай улсын иргэд рубльтэйгээ Монголд ир. Манай улсын иргэд төгрөгтэйгөө танай улсад очиг. Тэгээд хоёр улсын нэг нэг арилжааны банкиг сонгочихно. Тэр хоёр банк нь аль аль талын иргэддээ төгрөг рублийг нь солиод өгчихдөг байя гэж байгаа. Тэгэхээр хоёр Төв банкны Ерөнхийлөгч нарын түвшинд уулзах, хоёр улсын Засгийн газрын дэмжлэг авах шаардлага гарах бололтой.

-Оросын хэвлэлд Монголын талаас 1.5 тэрбум ам.доллар зээлэх хүсэлт тавьсан ч оросууд татгалзсан гэсэн байсан. Энэ чухам юу болсон юм бол? Биднийг өр зээлээ төлж чадахгүй гээд буцаасан гээд байх шиг?

-Манай Засгийн газраас тийм хүсэлт тавьсан. Би бол нэг их татгалзсан гэж бодохгүй байгаа. Зүгээр хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлбэ. Тэр төсөл, хөтөлбөрөө тодорхой болгоё гэсэн юм билээ. Манай Засгийн газрын хувьд ОХУ-тай хамтарч хэрэгжүүлэх маш олон төсөл, хөтөлбөр бий. Тэр бүгдийгээ тодорхой болгосон үед санхүүжилт олно.

-БИ ТӨВ БАНКНЫ БИЕ ДААСАН БАЙДЛАА ХАМГААЛНА-

-Жил бүр л УИХ дээр төсөв мөнгөний бодлого ярихаар Засгийн газар, Монголбанк нь хоёр тийшээ хараад суучихдаг. Эсвэл бүр эсрэгээрээ хоорондоо хуйвалдаад ч байгаа юм шиг, асуудлыг зөв шийдэж чадахгүй байна гэдэг шүүмжлэл гардаг. Таны ажлаа аваад баримталж байгаа бодлого Засгийн газартайгаа уялдаж байгаа юу, эсвэл тэрсэлдэж байгаа юу?

-Миний баримталж байгаа гол зарчим Төв банкны хараат бус байдал. Тийм учраас Төв банк хараат бус байдлаа хадгалж, бие даасан мөнгөний бодлогоо хэрэгжүүлэх ёстой. Гэхдээ Төв банкнаас явуулж байгаа мөнгөний бодлого Засгийн газрын санхүүгийн бодлоготой уялдах ёстой. Шинээр байгуулагдсан Засгийн газартай Монголбанк хамтарч ажиллаж чадаж байна гэж би үзэж байгаа.

-Хараат бус байдлаа хадгална гэхээр зарим тохиолдолд Засгийн газартайгаа зөрчилдөх, санал нийлэхгүй байх тохиолдол зөндөө л гардаг байх. Миний ойлгосноор ипотекийн зээлийн эх үүсвэрийг танайх руу шилжүүлэхэд Төв банк их дурамжхан хүлээж авсан байх?

-Ипотекийн хөтөлбөрийг анх Төв банкнаас санхүүжүүлж эхэлсэн. 2016 онд Ирээдүйн тэтгэврийн нөөц сан гэж Засгийн газар дээр байгуулаад, тийш нь санхүүжилтийг шилжүүлсэн. Гэхдээ л санхүүжилт Монголбанкнаас гарсан хэвээрээ байсан. Ингээд 2016 оны төсөвт тодотгол хийхдээ цаашдаа Ирээдүйн тэтгэврийн нөөц сангаар ипотекийн хөтөлбөрийг санхүүжүүлэх боломжгүй байна. Тийм учраас Төв банк энэ асуудлаа ав гэж бидэнд шилжүүлсэн байгаа. Бид хүлээж авснаас хойш нийтдээ 200 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтийг гаргаад байна. Нөгөө талаар Засгийн газрын нөхцөл байдлыг ойлгож байна. Урд нь Монголбанкнаас 3.8 их наяд төгрөгийг ипотекийн хөтөлбөрт зориулж гаргасан. Энэ нь нийт Монголын эдийн засагт Монголбанкнаас гаргасан мөнгөний бараг тал хувьтай нь тэнцэж байгаа.

-Тэгэхээр мөнгө хэвлээд гаргачихсан гэж ойлгож байгаа?

-Энэ чинь төсвийн мөнгөөр хийгдээгүй, Монголбанкнаас хэрэгжүүлсэн. Тийм учраас 3.8 их наяд төгрөг гаргачихсан. Одоо Монголбанкнаас ипотекийн санхүүжилтийн шинэ бодлого хэрэгжүүлж байна. Юу гэхээр 3.8 их наяд төгрөгөө дахиж нэмэхгүй. Харин 3.8 их наяд аас эргэн төлөлтөөрөө сар бүр 35-40 тэрбум төгрөг Төв банкинд орж ирж байгаа. Энэ мөнгийг буцаагаад ипотекийн зээлийн эх үүсвэр болгон гаргаж байна. Энэ бол маш зөв хувилбарыг олчихлоо гэж харж байгаа.

-Би Монголбанкинд яагаад мөнгө олох даалгавар өгчихөв өө гэж бодоод байгаа. Монголбанк зэх зээлээ зохицуулаад л байж байх ёстой шүү дээ. Гэтэл ипотекийг санхүүжүүлэх мөнгө олж ир гэхээр арай л хүнд ачаа болчихов уу гэж харж байгаа?

-Ер нь ипотекийн хөтөлбөрийг аливаа улс оронд Засгийн газар нь хэрэгжүүлдэг, Засгийн газрын хөтөлбөр байдаг. Гэхдээ бид шинэ мөнгө хэвлэх, шинээр мөнгө нийлүүлэхгүйгээр эргэн төлөлтөөр санхүүжүүлж байгаа учраас зөв механизм юм. Гэхдээ удаан ингэж явж болохгүй. Ер нь Засгийн газар санхүүжилтээ өөр дээрээ буцааж авах ёстой.

-ЭДИЙН ЗАСГАА ТЭЛЭХ БОЛОМЖ, ОРОН ЗАЙГ МӨНГӨНИЙ БОДЛОГООР БИЙ БОЛГОХ ЁСТОЙ-

-2017 онд инфляцийг 8 хувьд барина гээд амлалт өгчихсөн байгаа. Энэ амлалт биелэх боломжтой юу?

-Биелэх ёстой. Яагаад гэвэл одоо Монголын эдийн засагт дефляци яваад эхэлчихлээ. Юмны үнэ ханш буурч байна.

-Дефляци ер нь Монголд ойрын хэдэн жил үзэгдээгүй үзэгдэл байх. Энэ эдийн засагт хохирол хүргэж байгаа юу?

-Энэ их муу үзэгдэл. Тийм учраас бид дефляциас гарах, зохистой хэмжээний инфляцитай байх ёстой гэсэн байр суурьтай байгаа. Инфляцийн хэмжээг 2017 онд 8 хувиас хэтрүүлэхгүй гэдэг маань бид эдийн засгийн өсөлтийнхөө орон зайг тэлж өгч байна гэсэн үг.

-Засгийн газар эдийн засгийн өсөлтөө 3 хувьд хүргэнэ гэж байгаа. Энэ бодлоготой уялдуулж, Төв банк инфляцийг 8 хувь гэж тогтоож байгаа хэрэг үү?

-3 хувь гэдэг бол том зорилт. Том зорилтыг бид мөнгөний бодлогоороо дэмжиж өгье. Үүний тулд бодлогын орон зайтай байх ёстой гэж үзэж байгаа.

-Одоогоор эдийн засгийн өсөлт бараг хасах руу орчихсон байгаа. Тэгэхээр 3 хувь гэдэг бол том зорилт. Тэр зорилт биелэхгүй бол мөнгөний бодлогын зорилт бас биелэхгүй гэсэн үг үү?

-Нэгэнт л зорилт тавьж байгаа юм чинь хэрэгжүүлэхийн тулд газар сайгүй л маш сайн ажиллах хэрэгтэй. Үйлдвэр эрхлэгчдээ дэмжих хэрэгтэй байна. Гадаадын хөрөнгө оруулагчдын урмыг хугалаад, хөөж явуулдаг биш урьж авчирдаг болох, Монголд тодорхой бизнес, үйлдвэрлэл эхлүүлэх гээд маш олон ажил байна.

-ВАЛЮТЫН НӨӨЦИЙГ ЗАРЛАСАН НЬ ХАРИН Ч ЗӨВ БОЛСОН-

-Ам.долларын ханш өсөөд 2500 руу дөхөж байна. Монголбанк яагаад ханшаа барьж чадахгүй байна вэ гэдэг шүүмжлэл өрнөж байгаа. Монголбанк ам.долларын ханшийг ажиглаж байна гэж хэлснээсээ болоод улстөрчдөд ч нэлээн шүүмжлүүлж байх шиг байна?

-Ам.долларын ханшийг ажиглаж байна гэдэг бол Монголбанкнаас гаргасан мэдэгдэл дээр гарсан үг.

-Юунд нь ажиглаад байгаа юм бэ, юмаа хийгээч гээд байгаа юм биш үү?

-Ханш Монгол Улсад байгаа валютын нөөцөөр тодорхойлогддог. Надад нэг тэрбум 200 орчим сая ам.долларын нөөц байна. Би нэр хүндээ бодоод, ханшийг барих гэж байгаа нь энэ гээд долоо хоног бүр 100, 200 саяар нь интервэнц хийж эхэлбэл, нөөц маань маш богино хугацаанд шавхагдана. Гэтэл энэ мөнгө чинь миний мөнгө биш. Манай Монгол Улсын мөнгө. Таны ч мөнгө. Аливаа улс оронд дор хаяж гурван сарын импорттой тэнцэх хэмжээний нөөцтэй байх ёстой. Бидэнд 5 сарын нөөц байна. Ийм хэмжээний нөөцтэй байж байх хэрэгтэй. Би валютын нөөцөө хамгаалах ёстой гэдэг байр суурьтай байгаа.

-Тэгвэл та яагаад ажлаа аваад хэдхэн хоногийн дараа Монгол Улсын валютын нөөц шавхагдаад дуусчихсан, данс нь улайчихсан байна гэж зарласан юм бэ. Үүнээс болоод л ханш өсчихлөө гэдэг шүүмжлэл гарч байгаа шүү дээ. Тэр үед таныг болчимгүй үг хэлчихлээ гэж олон хүн шүүмжилсэн.

-Би тэр хэлсэн үгээ болчимгүй үг хэлсэн гэж бодохгүй байгаа. Ер нь улс орон ямар байдалд байгаа юм, би ямар ажил хүлээж авсан юм бэ гэдгээ УИХ-д хэлсэн. Түүнээс биш Монголын олон нийтэд хандаж хэлээгүй. УИХ-ын гишүүдийн асуултад хариулсан. Тэр бол Монголын төрийн эрх барих дээд байгууллага. Тэр байгууллагаас намайг томилсон. Тэр газраа очоод, эдийн засгийн нөхцөл байдал ийм байна гэдгийг л хэлсэн.

-Албаар зарлаагүй л юм байна...

-Надаас асуусан, би нөхцөл байдал ийм байна гэдгийг хэлсэн. Тэр нь ч зөв болсон. Манай ард иргэд улс орон ямар эдийн засагтай байна вэ гэдгээ мэдэж байх ёстой. Хоёрдугаарт, бизнес эрхлэгчид маань тэндээс маш том дохио авсан. Маш том бизнес эхлүүлэх гээд, төсөл, хөтөлбөр хөөцөлдөж байсан хүмүүс “Улс орон ийм болчиж, яах ёстой билээ...” гэж болгоомжилсон. Маш олон хүн эрсдэлтэй алхам хийхээс сэрэмжлүүлсэнд баярлалаа гэж надад талархлаа илэрхийлсэн шүү.

-Та тэгэхээр өөрөө муу нэр зүүгээд, бусад хүмүүст тусалсан гэсэн үг үү?

-Ийм байна гэдгийг хэлэх л ёстой. Бас нэг зүйл нь миний хэлсэн тоо нууц тоо биш. Та нар Монголбанкны вэб сайт руу ороод үз. Яг тэр тоо чинь байж л байгаа.

-Танд байгаа 1 тэрбум 200 сая ам.доллар бодитой хуримтлал биш. Хятадаас авсан зээл гэж яриад байгаа?

-Тийм.

-Тэгэхээр бодитой нөөц биш, хүнээс гуйж аваад, түр хадгалж байгаа мөнгө юм биш үү?

-Харин би үүнийг л УИХ-д хэлсэн юм. Ийм хэмжээний мөнгө байна. Гэхдээ авсан өр, зээлээ төллөө гэж бодоход бидэнд эх үүсвэр алга байна шүү гэдгийг хэлсэн. Төрийн эрх барьж байгаа, ажлаа эхлүүлж байгаа гишүүдэд би маш үнэтэй, бодитой мэдээлэл өгсөн гэж үзэж байгаа. Худлаа мэдээлэлтэй байж, яаж төр удирдах юм. Бодитой, үнэн зөв мэдээлэлтэй байх ёстой шүү дээ.

-МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЭРХ МЭДЛИЙГ БАГАСГАХ ХЭРЭГТЭЙ-

-Та ярилцлагынхаа эхэнд Төв банкны бие даасан байдлыг хадгална гэсэн. Гэхдээ Засгийн газар юм уу, УИХ-аас чиглэл өгөхөөр Төв банк биелүүлэхээс өөр аргагүй болдог шүү дээ. Тэгэхээр популист амлалтуудтай бодлогоо уялдуулах ч шаардлага гардаг байх. Ийм нөхцөлд та бие даасан байдлаа яаж хадгалах юм бэ?

-Юуны өмнө бид Төв банкны тухай хуульд өөрчлөлт оруулна гэж үзэж байгаа. Энэ өөрчлөлтөөр Монголбанкны Ерөнхийлөгчийн эрх мэдлийг бага зэрэг хумьж өгье гэж байгаа.

-Та өөрөө Төв банкны Ерөнхийлөгч байж, өөрийнхөө эрх мэдлийг багасгая гэж байгаа юм уу?

-Яг тийм. Та зөв ойлгосон.

-Яагаад?

-Төв банкны Ерөнхийлөгчөөр би ажиллаж эхлээд таван сар болж байна. Маш их ажилтай юм байна. Яагаад их ажилтай байна вэ гэхээр сайд Төрийн Нарийн бичгийн даргын ажлыг Төв банкны Ерөнхийлөгч давхар гүйцэтгэдэг юм байна.

-Тэгэхээр Сангийн яаман дээр дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга байх хэрэггүй гэж үү?

-Байх хэрэгтэй. Тийм учраас Төв банкны ерөнхийлөгчийн эрх мэдлийг багасгая гэж байгаа юм. Би өнөөдөр хүмүүсийг ажилд авч байгаа, ажлаас халж байгаа. Мөн торгууль, шийтгэл ногдуулж байгаа. Цалингийн хэмжээг тогтоож байгаа. Аж ахуй, санхүүгийн олон ажлуудыг хүртэл анхаарч байгаа. Дээр нь Төв банкны Ерөнхийлөгчийн бодож байх ёстой том ажлуудыг хийнэ. Ийм том ажлын хажуугаар гэнэт санхүү, аж ахуйн асуудлууд хүртэл орж ирнэ. Тэгэхээр маш их ажилтай байдаг юм байна.

-Та тэгвэл ямар эрхээ хасуулья гэж байгаа юм?

-Төв банкны Ерөнхийлөгч бодлогын том асуудлаа харж байх ёстой.

-Аж ахуйн ажлуудыг больё гэж үү?

-Аж ахуйгаас гадна бие дааж гаргадаг маш олон шийдвэрүүд байна. Жишээлбэл, надад Мөнгөний бодлогын зөвлөл гэж байгууллага бий. Мөнгөний бодлогын зөвлөл дээр тал бүрээс нь ярьж, хэлэлцэж байгаад шийдвэрээ гаргадаг. Тэр шийдвэрийг нь Монголбанкны Ерөнхийлөгч гарын үсэг зурж, баталгаажуулдаг. Өөрөөр хэлбэл, бүх эрх мэдэл над дээр байна. Бүх ачааг авчраад Ерөнхийлөгчид аччихсан байна.

-Мөнгөний бодлогын шийдвэрийг нэг хүн л гаргаад байна гэж үү. Зөвлөлөөр биш?

-Тийм. Гэтэл нэг хүний гаргаж байгаа шийдвэр дандаа зөв байж чадахгүй. Тэгэхээр хамтын шийдвэрээр шийдвэрээ гаргадаг байх ёстой.

-Энэ хуулийг УИХ дэмжих болов уу?

-Дэмжинэ гэж бодож байна.

-БОДЛОГЫН ХҮҮГ НЭМСНЭЭР МОНГОЛ ТӨГРӨГ ҮНЭГҮЙДЭХ БОДИТОЙ АЮУЛЫГ ХОЛДУУЛСАН-

-Эдийн засгийн хүндрэл, хямралтай байгаа үед бусад улс орны Төв банкууд дандаа бодлогын хүүгээ бууруулах замаар шийддэг. Гэтэл Монголбанк эсрэгээр нь бодлогын хүүгээ нэмээд байна. Энэ нь эргээд эдийн засагт таагүй нөлөөлөх биш үү?

-Ерөнхий нөхцөл байдал намайг бодлогын хүүг нэмэхээс өөр аргагүй болгож шахсан. Яагаад гэвэл 2016 оны УИХ-ын сонгуулийн өмнө нийтдээ Монголын эдийн засагт 500 тэрбум төгрөгийн нийлүүлэлт хийгдсэн. Энэ УИХ-аар хэлэлцэгдээгүй. Засгийн газар, Монголбанкны түвшинд ярьж байгаад, Монголбанкнаас эх үүсвэрийг гаргасан. Ингэхдээ 15 жилийн хугацаатай, жилийн 1 хувийн хүүтэйгээр эдийн засагт хийчихсэн. Хоёрдугаарт, яг сонгуулийн өмнө зургаадугаар сарын 20-доор 400 орчим сая ам.доллар Монголын эдийн засгаас гэнэт гараад явчихсан. Бид Эрдэнэт үйлдвэрийн худалдан авалттай холбоотой гэж харж байгаа. Нэг талд нь асар их төгрөгийн эх үүсвэр гарчихсан. Нөгөө талд нь долларын хомсдол бий болчихсон, ийм нөхцөлд би Монголбанкны Ерөнхийлөгчөөр ирсэн.

-Азгүй ч юм шиг?

-Азгүй ч арай биш. Ер нь бол хүнд нөхцөлд ирсэн. 500 тэрбум төгрөг долларжих процесс руу явах гээд байсан. Би мөнгөний бодлогын хүүгээ 10.5 хувь байсныг 15 болгож нэмсэн. Үүний цаад учир юу гэхээр Төв банкнаас үнэт цаас гаргадаг. Үнэт цаасыг арилжааны банкуудад худалдаад чөлөөт мөнгийг 15 хувийн хүүтэйгээр өөр дээрээ худалдаж авч байгаа юм. Өөрийнхөө мөнгөн тэмдэгтийн үнэ цэнийг л нэмж байгаа юм. Манай төгрөг үнэгүйдээд ирсэн. Төгрөгийн хадгаламжтай хүмүүс доллар болгоё гэх хандлага бий болсон. Монгол төгрөг үнэгүйдэх аюул бодитойгоор тулгарсан. Тэр нөхцөлд би монгол төгрөгийг үнэтэй болгох Төв банкны хамгийн хүчтэй ганц зэвсгээ л хэрэглэсэн. Бас нэг зүйлийг хэлэхэд Төв банкны үнэт цаас өмнө нь долоо хоногийн хугацаатай байсныг

гурван сарын хугацаатай болгосон. Тэр мөнгийг нь гурван сарын хугацаатай Төв банкин дээр авчраад түгжихэж байгаа юм. Валют руу хөрвөх гээд байсан мөнгийг Төв банкин дээрээ түгжиж байгаа юм. Нийтдээ 1 их наяд орчим төгрөгийг Төв банкны үнэт цаасны хүүгээ нэмж байж, Төв банкин дээрээ цуглуулж авсан.

-Гэхдээ та төгрөг үнэгүйдэхээс сэрэмжилсэн гэж байгаа ч өнөөдрийн байдлаар төгрөгийн ханш аажмаар унасаар байна. Цаашдаа доллар ер нь 3000 гарч ч магадгүй гэж яриад байгаа. Та үүнийг зүгээр л ажиглаад суух юм биш үү?

-Та нар ийм аюултай юм ярьж болохгүй. Сэтгүүлч хүн нийгэмд маш их нөлөөтэй. Та ингээд 3000 болж магадгүй гээд уриалчихаж байгаа байхгүй юу. УИХ-ын гишүүд нь ч чуулганы танхимдаа уриалаад, сэтгүүлчид нь ч уриалаад байж болохгүй.

-Уриалаагүй. Эдийн засагчид нь хэлээд байна шүү дээ?

-Үгүй ээ, тэр бол буруу. Та нар монгол хүн, эх орончид юм бол монгол төгрөгөө хамгаал. Монгол төгрөгөө хамгаалах нь хүн бүрийн үүрэг. Би ямар ч байсан төгрөгийн ханшаа тогтворжуулаад авлаа. Тийм учраас сүүлийн хоёр сарын хугацаанд би гурван сарын хугацаатай үнэт цаасны худалдаагаа зогсоочихсон. Тэгэнгүүт Төв банкны үнэт цаасыг худалдаж авч байсан банкууд, хувь хүмүүс Засгийн газрын үнэт цаасыг худалдан авч эхэлсэн. Сүүлийн үед Төв банкин дээр хуримтлагдаж байсан тэр их хөрөнгө мөнгө Засгийн газрын өрийн бичиг рүү шилжээд, Засгийн газар бас асуудлаа шийдчихэж байгаа юм.

-Төв банк бодлогын хүүгээ нэмэнгүүт арилжааны банкууд хүүгээ нэмчихдэг. Эдийн засаг хүнд байхад зээлийн хүүг улам нэмэгдүүлж, бизнесээ шахаж, хавчлаа гээд л шүүмжилж байна?

-Зээлийн хүү нэмэгдэх нь аргагүй л дээ. Яагаад гэвэл бодлогын хүү өсчихөөр арилжааны банкууд зээл олгох ёстой мөнгөөрөө ямар ч эрсдэлгүй ТБҮЦ худалдаж аваад эхэлж байгаа юм. Энэ бол эдийн засагт орох ёстой хөрөнгө мөнгийг тодорхой хэмжээгээр түгжиж байгаа. Үүнийг бид ойлгож байгаа. Цаашдаа бид тодорхой үе шаттайгаар бодлогын хүүгээ бууруулна. Манай Монголбанкны Судалгаа, статистикийн газар судалгаа хийж үзсэн. Төв банкны үнэт цаасны хүү өссөн нь зээлийн хүүг 0.9 пунктээр нэмэгдүүлэхэд нөлөөлсөн гэх дүгнэлтийг надад танилцуулсан.

-НУУХ ЗҮЙЛ ҮГҮЙ, НАДАД ГЭР БҮЛИЙН БИЗНЕС БИЙ-

-Яриагаа арай энгийн сэдэв рүү оруулья. УИХ-д Та дөрвөн удаа сонгогдсон. Тэр хугацаандаа Сангийн сайдын албыг ч хашиж байсан. Төсвийн байнгын хорооны даргаар ажиллаж байсан гэхээр төсөв, мөнгөний бодлогын алдаа, оноог та сайн мэднэ гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ хугацаанд таны хөрөнгө орлого хэр зэрэг нэмэгдсэн

бэ? Та УИХ-д байхдаа ч дандаа төсөв, мөнгөтэй холбоотой албан тушаалуудад ажиллаж байсан?

-2008 он хүртэл УИХ-ын гишүүн, Сангийн сайдаар ажиллалаа. Тэр хооронд миний хөрөнгө орлого нэмэгдээгүй. Ямар түвшинд байсан, тэр хэмжээндээ л байгаа.

-Сангийн сайд байсан хүний хөрөнгө орлого нэмэгдэх л ёстой гэж хардаг шүү дээ?

-Та тэр үеийн миний хөрөнгө орлогын мэдүүлгийг аваад үз. 1990 онд яаж эхэлсэн, жил бүр алхам алхмаар өсөөд, бас нэг сургууль хамтран байгуулалцсан гэх зэрэг. Тэр бүгдийгээ би мэдүүлээд л явж байсан.

-Та тэгэхээр гэр бүлийн бизнестэй юм байна?

-Тийм.

-Ямар сургууль билээ?

-1997 онд байгуулсан Сан дээд сургууль.

-Одоо тэгвэл тэр сургуулиасаа хувь, ногдол ашиг авдаг уу?

-Сургуулийн хувь ч гэж юу байхав. Сургууль маань ерөнхийдөө хөгжиж байгаа.

-Ногдол ашиг гэж авдаг уу?

-Сургуулиас ногдол ашиг авна гэж байдаггүй юм. Сургууль өөрөө л хөгжих ёстой.

-Өөр танд гэр бүлийн бизнес байгаа юу? Сургуулиас гадна?

-Байгаа. Би хөрөнгө орлогын мэдүүлэг дээрээ сүүлийн хоёр жил танилцуулсан. Бүгдийг нь тусгасан. Ороод үзээрэй.

-Улс төрд мөнгөтэй байж амжилт гаргадаг байх. Наад зах нь сонгуульд оролцоход хөрөнгө мөнгөний асуудлаас эхлээд хэцүү байх. Таньд бол тийм асуудал нэг их тулгардаггүй байх нь?

-Тийм.

-1990-ээд оны үед парламентад сууж байсан. Тэгвэл хажуугаар нь бизнесээ яаж амжуулж байсан бэ?

-Миний хийдэг бизнес ч юу байх вэ. Гэр бүлийн бизнес шүү дээ.

-Ямар чиглэлээр?

-Худалдаа, хөрөнгө оруулалт гэх мэтчилэн. Миний бизнес бол хүний гар харахгүйгээр ажил, амьдралаа авч явах тийм л хэмжээнд явдаг.

-СҮҮЛИЙН 8 ЖИЛД ГЭР БҮЛДЭЭ ХАНГАЛТТАЙ ЦАГ ЗАРЦУУЛСАН-

-Төв банкны Ерөнхийлөгчийн цалин УИХ-ын гишүүдийнхээс мэдээж өндөр байх?

-Миний цалинг УИХ-аас тогтоож өгдөг. Шадар сайдтай тэнцэх хэмжээний цалин гэхээр тэр хэд ч байж болно.

-Гурав, дөрвөн саяас хэтрэхгүй байх л гэж бодож байна. Энэ хэмжээний цалин таны ажлын ачаалал, хариуцлагатай харьцуулахад хангалттай гэж бодож байна уу?

-Төрийн хишиг шүү дээ. Би тэрийг чамлаж болохгүй. Олон түмнээс хүлээлгэсэн итгэл байна. Тэр итгэлийг даагаад ажиллах ёстой л гэж бодож байгаа.

-Та гэр бүл хэдүүлээ билээ?

-Дөрвүүлээ. Хоёр хүүхэдтэй.

-Гэр бүлдээ хэр зэрэг цаг зарцуулж чаддаг вэ? Улс төрд байхдаа амждаггүй л байсан байх. Одоо Төв банкны Ерөнхийлөгч гэхээр цаг зав хомс шүү дээ?

-2008 онд УИХ-ын гишүүнээр ажиллаж дуусаад, найман жил ерөнхийдөө чөлөөт иргэн явлаа. Маш их завтай байлаа. Олон хүнтэй танилцлаа. Дэлхий ертөнцөөр явж, газар орон үзлээ. Нэлээд ном уншлаа. Мэдлэг боловсролоо ахиуллаа. Амьдрал ахуйгаа бодож, бизнесийн чиглэлээр янз янзын зүйлийг оролдлоо. Тэр үедээ би гэр бүлдээ хангалттай цаг, завьг зарцуулж, хамт байж, сайхан байлаа.

-Та хүүхдүүдийнхээ боловсролд хангалттай анхаарсан гэж боддог уу?

-Хангалттай анхаарсан. Маш сайн боловсрол эзэмшсэн.

-Одоо сургуулиа төгссөн үү?

-Нэг нь төгссөн. Нөгөө нь сураад л явж байна.

-Ямар мэргэжлээр төгсөв?

-Том нь аудитор болсон. Аудитын том компанид ажиллаж байгаа. Бага нь урлаг судлаач болсон.

-МИНИЙ ЭХНЭР МАНАЙ ГЭР БҮЛИЙН НОЁН НУРУУ-

-Амжилттай яваа эр хүний ард ухаалаг эмэгтэй байдаг гэсэн үг бий. Та эхнэрээ танилцуулаач

-Манай эхнэрийг Алимаа гэдэг. Бид Эрхүүгийн Улс ардын аж ахуйн дээд сургуульд хамт сургууль төгсөөд, Монголдоо хүрч ирээд амьдрал ахуйгаа дээшлүүлэх гэж хоёулаа их зүтгэлээ. Эрхүүгээс төгсөж ирснээс нэг жилийн дараа намайг Хөвсгөл аймгийн Цагаан уул суманд эдийн засагчаар томилсон. Цагаан Уул сумын нэгдлийн дарга Аварзэд баатар. Хөдөлмөрийн баатар, үнэхээр мундаг эр байсан. Тэр хүний дэргэд нэг жил Цагаан уул сумын эдийн засагчаар ажилласан. Ар гэрийнхээ амьдралыг манай эхнэр аваад л явж байсан. Нэг жилийн дараа дуудагдаад хүрээд иртэл дахиад томилолт өгсөн. Архангай аймгийн Их тамир суманд Хөдөлмөрийн баатар Минжүүр гэж мундаг хүн Тунгалаг тамир гэдэг хоршоо байгуулсан байна. Тэнд очиж, нэг жил эдийн засагчаар ажилла гэсэн. Би тэнд нэг жил болоогүй, найман сар ажиллаад байж байтал дуудаж авчраад, Намын дээд сургуульд багш болгосон. Одоогийн Удирдлагын академи шүү дээ. Тэр хооронд амьдрал ахуйгаа өөрөө авч яваад, зохицуулаад сурчихсан манай том ноён нуруу, гал тогоо тэнд байна.

-Эхнэрээ ноён нуруу гэж ярьж байгаа эр хүнийг анх удаа харж байна. Эрчүүд бол өөрсдийгөө л ноён нуруу гэж ярих дуртай шүү дээ. Та эхнэрээ ингэж тодорхойлж байна гэхээр их л онцгой хүн болж таарлаа.

-Би эхнэрээ магтдаг олон сайхан хүнтэй таарч байсны нэг нь Пунсалмаагийн Очирбат гэж боддог. Надад Цэвэлмаа эгчийн талаар гайхалтай ярьсан. Би тэрэнд их баярлаж, өөрийнхөө эхнэрийг ингэж ярьдаг, ингэж үнэлдэг, ингэж магтдаг, ямар гайхалтай эр вэ гэж үлгэр жишээ авч амьдарч байгаа.

-Оюутан байхдаа эхнэртэйгээ танилцсан гэж байна. Ямар чанар нь Танд илүү таалагдсан бэ?

-Би 1980-аад онд тарчиг байсан л даа. Энд амралтаар ирэхээрээ бага зэрэг хиамтай ирдэг. Хиамаа хөргөгчинд хадгалж байгаад бага багаар нь зүсэж иддэг ганц бие оюутан байж байтал янзтай сайхан хоол хийдэг бүсгүй таарсан.

-ОРЧИН ҮЕИЙН ХҮҮХДҮҮД ДЭЛХИЙН ХҮН БОЛЧИХСОН, ТИЙМ УЧРААС ТЭДНЭЭС СУРАЛЦАХ ЗҮЙЛ ИХ-

-Таныг амжилттай явахад эхнэр чинь бас их дэм болсон юм байна. Одоо таны хүүхдүүд яг таны хүссэн хэмжээнд хүрэв үү? Гэр бүл зохисон уу? Та хүргэн, бэрээ өөрөө шинжих үү?

-Нэг нь нөхөртэйгөө хамт амьдарч байгаа. Нөгөө нь бидэнтэй хамт байна.

-Хүүхдүүдийнхээ хувийн амьдралд оролцдог уу?

-Үгүй. Хүүхэд гэдэг бол бүгд бие даасан ертөнцүүд. Тийм учраас бид амьдралд нь оролцоод, хутгалдаад байдаггүй. Гэхдээ их мундаг хүүхдүүд л дээ. Тийм болохоор харин

бид тэднээсээ суралцах хэрэгтэй. Яагаад гэхээр орчин үеийн залуучуудаас сурах юм бидэнд их байна.

-Бусад хүмүүс хүүхдүүдээ анхаарал хандуулж, амьдрал ахуйг нь зааж, чиглүүлэх ёстой гэдэг. Та харин эсрэгээрээ хүүхдүүдээсээ суралцах ёстой гэж байна.

-Суралцах ёстой. Яагаад гэвэл орчин үеийн залуус маань үнэндээ дэлхийн хүмүүс болчихож. Уншдаг номыг нь уншаад, судалдаг эрдмийг нь судлаад, төгсдөг сургуулийг нь төгсөөд, дэлхийн хүмүүсээс дутахгүйгээр бодож, ярьж, сэтгэж чадаж байна. Тийм болохоор бид тэднээс суралцах хэрэгтэй. Тэр тусмаа мань мэтийн 50-аад насныхан 20-30 насны залуучуудын юу ярьж, хэлж байгааг маш анхааралтай ажиглаж, суралцаж байх ёстой.

-Хүүхдүүд томрохоор өөртөө цаг зарцуулах боломж гардаг гэж би ойлгодог. Та өөртөө хэр цаг зав гаргаж байна вэ? Чөлөөт цагаа яаж өнгөрүүлдэг вэ?

-Чөлөөт цагаа голдуу өөрийгөө боловсруулах, ном унших, амрах, аялах дуртай. Тийм зүйлд л сүүлийн хэдэн жилийн чөлөөт цагаа зарцууллаа.

-Их аялсан уу?

-Их аялсан. Дэлхий ертөнцийг үзсэн. Дэлхий жижигхэн гэдгийг ойлгосон. Олон хүнтэй танилцлаа. Их сайхан хүмүүстэй найз нөхөд боллоо.

-Та аав ээжээсээ хэдүүлээ вэ?

-Аав ээжээсээ зургуулаа. Манай аав, ээж хоёр 70 гаран насны хүмүүс, өдөр болгон хүүдээ санаа зовоод л сууцгааж байна. Саяны найман жилд чөлөөтэй, санаа зовох юмгүй сайхан байж. Одоо бол чи их хүнд хэцүү ажилд оччихлоо. Бид байнга чамд амжилт хүсч байна, ерөөл тавьж байна гээд л сууж байгаа. Би өөрөө таван дүүтэй.

-Та тэгэхээр айлын том юм байна. Бусдаасаа илүү ачаа үүрдэг байх?

-Айлын том учраас дүү нартаа тусалж дэмжих, залах, чиглүүлэх зүйл байлгүй яах вэ. Гэхдээ манай дүү нар мундаг хүмүүс. Бүгд өөр өөрсдийнхөө ажил төрөлдөө их амжилттай, сайхан явж байгаа.

-НАДАД ХАТУУ ЗАН ЧАНАР БИЙ, ЭНЭ БОЛ НЯЛЦГАЙ ХҮНИЙ ХИЙХ АЖИЛ БИШ-

-Төв банкны Ерөнхийлөгч болонгуут урьд нь Тантай найзалдаггүй, анзаардаггүй байсан хүмүүс тал засч эхлэх зүйл анзаарагдаж байна уу?

-Би саяын найман жилд чөлөөт иргэн болоод амьдарлаа. Тэр найман жилийн хугацаанд хэн нь хэн бэ гэдэг маш тодорхой болчихсон.

-Найз нөхөд, хамаатан садан, ах дүү нараас чинь энд тэнд ажилд оруулаад өгөөч, ийм тийм мөнгөн тусламж, зээл олгоод өгөөч гэсэн хүсэлт их ирж байгаа байх?

-Нэг их биш ээ. Намайг хүмүүс мэднэ. Ерөнхийдөө зарчимч хүн гэж боддог. Тийм учраас хувийн талын хүсэлт барьж орж ирэх тохиолдол бараг байхгүй.

-Таныг анзаараад байхад их хатуу зан характертай хүн юм болов уу гэж харагддаг. Ялангуяа Их хурлын гишүүдийн асуултад хариулахдаа их тийм зуунги байдлаар хариулж байх шиг харагддаг?

-За тэр тал дээр би дүгнэлт хийе. Ер нь бол характер надад байгаа шүү. Би тэрнийгээ мэднэ. Характергүйгээр Монголын төрд зүтгэнэ, тэр тусмаа ийм хариуцлагатай ажилд ажиллана гэж байдаггүй юм. Энэ чинь нялцгай хүний хийдэг ажил биш шүү.

-Өөрөөр хэлбэл, үгүй гэж хэлж чаддаг зориг хэрэгтэй гэж үү?

-Үгүй гэж хэлэхгүйгээр энэ хорвоод амьдрах маш хэцүү. Энэ зөвхөн албан тушаал хашдаг хүмүүсийн хувьд ч биш. Хэн нь ч бай, буруу юман дээр үгүй гэж хэлж чаддаг байх хэрэгтэй. Өөрийн гэсэн бодолтой байх хэрэгтэй. Ер нь үгүй гэж хэлж чаддаггүй хүн маш өрөвдөлтэй шүү. Үүнийг манай залуу үеийнхэн их анхаарах хэрэгтэй. Буруу юманд уруу татах гэсэн, муу юманд оруулах гэсэн маш их оролдлого энэ хорвоо ертөнцөд гарна. Хүний амьдралыг туулахад тийм зүйлд уучлаарай, би чадахгүй, үгүй гэж хэлдэг байх хэрэгтэй. Энэ их чухал зан чанар.

-Энэ зан чанар чинь таны ойр дотны хэн нэгнийг гомдоосон болов уу?

-Магадгүй л юм. Болохгүй юман дээр уучлаарай, ах нь чадахгүй, боломжгүй зүйл гээд л хэлэх хэрэгтэй.

-НАМСРАЙ БУРХАНДАА ӨГЛӨӨ БҮР УЛСАА ДААТГАН ЗАЛБИРДАГ-

-Та хэр шүтлэгтэй вэ? Таны ажлын өрөөний ард талд их том бурхан байгаа харагдлаа.

-Энэ бол их эртний бурхан. 200-300 жилийн түүхтэй, эртний Намсрай бурхан. Манай Эрдэнэсийн санд байсныг шүншиглээд, энд байрлуулсан. Байршуулах ажлыг нь Монголбанкны Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан С.Моломжамц гуай хийсэн юм билээ. Сангийн яам 1911 оны арванхоёрдугаар сарын 29-ний өдөр байгуулагдсан. Тэгээд Намсрай бурханыг тахиж эхэлсэн. Ингээд сайд нар нь бие биендээ уламжлаад явж байгаад 1937 оны хэлмэгдүүлэлтийн үед бурханаа гаргасан юм билээ. Гэхдээ тэр үед ажиллаж байсан сайд нь зурмал Намсрай бурханыг нуугаад, халаасандаа хийгээд аваад үлдчихсэн. Тэгээд социализмын үед ч бас сайд нар ажлаа хүлээлцэхдээ бие биендээ Намсрай бурханаа шилжүүлж өгч байсан юм билээ. 1990-ээд оны үед яасан нь мэдэхгүй, тэр бурхан алга болсон байгаа юм. Би Сангийн сайдаар ажиллаж байхдаа 2007 онд Сангийн яамыг дахин

Намсрай бурхантай болгосон. Би сая Сангийн сайдтай уулзахад ерөөнийхөө ард залчихсан, идээ будаагаа тавьчихсан, сайхан л харагдсан. Манай Монголбанкинд байгаа Намсрай бурхан бол их эртний юм. Би өглөө болгон идээ, будаагаа өргөөд, залбирдаг. Гэхдээ би хэзээ ч өөрийнхөө төлөө залбирдаггүй. Монгол Улсыг аврал, ивээлдээ аваач, Монголын ард түмэнд туслаач, улс орныг маань цэцэглүүлж, хөгжүүлж өгөөч гэж өглөө болгон залбирч байгаа.

-Та тэгэхээр багагүй шүтлэгтэй хүн байх нь?

-Би шүтлэгтэй. Манай ээжийн талын дөрвөн үеэрээ бүгд бурхан шашны лам хүмүүс байсан. Аавын талынхан маань харин хар хүмүүс байсан. Увс аймгийн хүмүүс. Манай өвөө бас энэ Монголбанкны ажилтан байсан. Манай өвөө Увсын Монголбанкинд ажилладаг хүн байсан, мөнгө тоологч. Гэхдээ 7 настайдаа сүмд очоод, 21 настайдаа сүм хийдээсээ гараад Ховдод очиж сургуульд сураад, төгсөж ирээд Увс аймгийн банкны захирлаар анх томилогдсон Жаргалжав гэж өвгөн байсан. Сүүлд настай болчихоод заавал хажууд нь нэг хүн байж, цайг нь чанаж өгч байх хэрэгтэй болсон. Тийм хүнээр манай ээж намайг долоон настай байхад томилсон. Тэгээд би өвөөгийнхөө хажууд өссөн. Өвөө маань шөнөжин ном уншаад, залбираад суучихна. Би яг хажууд нь тэрийг харж өслөө. Манай өвөө өдөр нь банкны ажилтан, орой нь лам. Цаг хатуу байсан учраас заримдаа шөнө нууцаар ирж, манай өвөөтэй уулзаж, засал хийлгэнэ. Би тэрийг нь хөнжлийнхөө завсраар хараад хэвтэж байгаа юм. Өнгөрсөн 2014 онд Монголбанкны 90 жилийн ой болоод, альбом гаргасан байна. Тэр альбомон дээр манай өвөөгийн зураг байна лээ. Анхны банк үүсгэн байгуулсан хүмүүсийн нэг гээд.

-Таныг томилогдоогүй байхад гарсан альбом байх нь...

-Харин энд ирээд л тэр альбомыг харлаа. Манай өвөөгийн зураг гарч ирж байна. Би ээждээ аваачаад бэлэглэчихсэн.

-Өвөө тань банкны захирлаар ажиллаж байж. Та хажууд нь өссөн гэхээр багаасаа мөнгөний үнэ цэнийг хэр мэдэрч өссөн бэ?

-Сайн хэлж мэдэхгүй юм. Миний бага нас социализмын амаргүй цаг үед л өнгөрсөн. Аав ээжээсээ хэдэн төгрөг авч л явдаг байлаа. 16 настайдаа 10 дугаар анги төгссөн. Эрхүүгийн улс ардын аж ахуйн дээд сургуульд суралцаж байхад 70 рублийн цалин өгдөг байсан. Би очоод онц сураад, 50 хувийн нэмэгдэл авна. Ингээд 70 рублийн 50 хувь гэхээр 105 рубль гэдэг бол тэр үед маш их мөнгө шүү.

-Сүүлийн үед гадны банк оруулж ирэх талаар нэлээн ярих боллоо. Та Төв банкны Ерөнхийлөгчийн хувьд үүнийг юу гэж бодож байгаа вэ?

-Ер нь гадны банк байгаа шүү дээ, бидэнд. Тухайлбал, Худалдаа хөгжлийн банкны хувьцааны дийлэнх хувийг United Banking Corporation гэдэг гадаадад бүртгэлтэй банк

эзэмшиж байна. Хас банкны хувьцаа эзэмшигчээр дэлхийн томоохон санхүүгийн байгууллагууд Европын сэргээн босголт, Хөгжлийн банк, Азийн Хөгжлийн банк гээд байна. ХААН банкны хувьцааны талаас илүү хувийг Японы хөрөнгө оруулагч эзэмшиж байна. Гэх мэтчилэн гадны банкууд Монголд ороод ирчихсэн, үйл ажиллагаа явуулж байгаа гэж хэлж болно.

-Таны хэлж байгаа банкуудын хөрөнгө оруулагчид хувийн хэвшлийн банкууд шүү дээ. Тэгвэл аль нэг улсын төрийн эзэмшилтэй банкийг оруулж ирэх нь зөв үү, буруу юу? Эдийн засаг, үндэсний аюулгүй байдалд эрсдэлтэй гэх эргэлзээ байна?

-Тийм учраас гадаадын банкуудыг Монголд оруулахдаа бид эхлээд хууль эрх зүйн орчноо цоо шинээр үүсгэн байгуулах ёстой. Хуулиндаа гадаадын ямар банкийг Монголд ажиллахыг зөвшөөрөх вэ гэдгээ тусгаад өгчих ёстой. Үүн дээр би маш тодорхой байр суурь баримталж байгаа. Өнөөдөр үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкуудын зах зээл рүү гадны банкууд өрсөлдөж орох ёсгүй. Үйл ажиллагаа явуулбал, цоо шинэ буюу хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж болно. Тэгэхээр хөрөнгө оруулалтын банкууд байх ёстой. Хөрөнгө оруулалтын гэхээр зөвхөн гадны банк байна гэж ойлгож болохгүй. Монголын банкууд хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулж болно шүү дээ. Тэгэхээр Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийг УИХ-аар батлах байх. Тэрний дараа хуулийн хүрээндээ асуудлаа ярья гэж бодож байгаа.

-Гадны банкууд оруулж ирлээ гэхэд жишээ нь хадгаламж татахгүй гэж байна. Үүн дээр ямар та ямар байр суурьтай байгаа вэ?

-Би сая хэлсэн, үндэсний банкуудын хийж байгаа үйл ажиллагаатай хутгалдаж, өрсөлдөх хэрэггүй. Тухайлбал, хадгаламж авахгүй, хувь хүнд зээл өгөхгүй, хуулийн этгээдэд хөрөнгө оруулалтын чиглэлээр зээл өг. Олгож байгаа зээлийн хэмжээ өндөр, хүү нь бага, хугацаа урт байх ёстой. Гэх мэтчилэн зохицуулалтыг хийж байж, дараа нь асуудлаа ярих ёстой.

-Үе үеийн Төв банкны Ерөнхийлөгч нар өөрсдийн ажиллаж байх хугацаандаа Төв банкинд болон улсынхаа эдийн засагт тодорхой өөрчлөлт хийхийг зорьдог. Таны хувьд ирэх зургаан жилд үүнийг л хийчихвэл Н.Баяртсайханы гэсэн тодотголтой болох нь гэх зүйл байна уу?

-Би хүрч ирээд Монголбанкны таван шинэчлэл гэдэг бодлогыг дэвшүүлсэн. Нэгдүгээрт, Төв банкны хууль эрх зүйн орчноо шинэчилье. Тухайлбал, Монголбанкны тухай хуулиа шинэчилье. Банкны тухай хууль, Эрдэнэсийн сангийн тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль, Үндэсний төлбөр тооцооны системийн тухай цоо шинэ хуультай больё гэх мэтчилэн. Хууль эрх зүйн орчны шинэчлэл. Хоёрдугаарт, хүний нөөцийн чиглэлээр маш том шинэчлэл хийе гэж байгаа. Өндөр хөгжилтэй оронд сайн боловсрол эзэмшиж ирсэн залуучуудаа дэмжих ёстой. Энэ бол миний шинэчлэлийн хоёр дахь хэсэг. Гуравдугаарт, Төв банкныхаа ажиллах орчин, нөхцөлийг сайжруулъя. Техник

технологийн сүүлийн үеийн ололт, амжилтуудыг нэвтрүүлэх. Мөн ажиллах арга барилыг ч бас өөрчлөх шаардлага байна. Төв банк гэдэг бол арилжааны банкуудаа зөвхөн шалгаж, хянаж байх ёстой гэсэн хандлагын талын юм байх шиг байна. Үүнийг өөрчлөх хэрэгтэй. Дөрөвдүгээрт, олон нийттэй харилцах харилцааг шинэчлэх. Би Хэвлэл, мэдээллийн албаа нэлээд хүчирхэг болгож байгаа. Урьдын адил нуугдмал, хаагдмал байхаа больё, бодлогоо ярьдаг больё. Хаалтын гэрээ гэж байгуулаад, хэдэн төгрөг өгөөд өөрсдийгөө магтуулдаг байсныг зогсооно. Бид хэвлэл, мэдээлэлтэй ажиллана, гэхдээ хамтын ажиллагаа явуулна. Муу, сайн зүйл байвал илэн далангүй л ярилцъя. Монголбанк нээлттэй ажиллана.

-Ярилцсанд баярлалаа.